



**НИЙСЛЭЛИЙН  
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 11 сарын 05 өдөр

Дугаар А/524

Улаанбаатар хот

**Ажлын хэсэг байгуулж, удирдамж  
батлах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын дүрмийн 3.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Нийслэлийн өмчийг эзэмшүүлэх гэрээ"-ний биелэлтийг дүгнэж, үнэлэлт дүгнэлт өгөх ажлын хүрээнд нийслэлийн 9 дүүргийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн "Амгалан", "Өргөө", "Хүрээ" амаржих газруудын гэрээний биелэлт, эд хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт, шалгалт хийх үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар, шалгалтын удирдамжийг хоёрдугаар хавсралтаар, гэрээний биелэлт дүгнэх хүснэгтийг гуравдугаар хавсралтаар, шаардагдах зардлыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2. Гэрээ дүгнэхтэй холбогдон гарах зардлыг батлагдсан төсвийн дагуу олгохыг Ерөнхий нягтлан бодогч /Н.Уранчимэг/-д зөвшөөрсүгэй.

3. Дээрх ажлыг батлагдсан удирдамжийн дагуу гүйцэтгэн, холбогдох санал дүгнэлт гаргаж, 2020 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор дүнг нэгтгэн байгууллагын Удирдлагын зөвлөлд танилцуулахыг Ажлын хэсгийн ахлагч /Д.Рэнцэнбямба/-д даалгасугай.


ДАРГЫН ҮҮРЭГ  
ГҮЙЦЭТГЭГЧ



Ш.ҮНЭНБАТ

115060001339

Нийслэлийн Өмчийн, ашиглалт удирдлагын  
газрын даргын 2020 оны .11... дугаар сарын  
..05..... өдрийн А/524.. дугаар тушаалын  
нэгдүгээр хавсралт




Ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Ажлын хэсгийн ахлагч:	Д.Рэнцэнбямба	Орлогч дарга
<b>Сүхбаатар, Баянзүрх дүүрэгт :</b>		
	М.Мандах	Өмчийн мэдээлэл хяналт, ашиглалтын хэлтсийн дарга
	С.Ариунжаргал	Өмчийн төлөөлөл, менежментийн хэлтсийн мэргэжилтэн
	Н.Болормаа	Өмчийн төлөөлөл, менежментийн хэлтсийн мэргэжилтэн
	Т.Оюунсүвд	Өмчийн мэдээлэл хяналт, ашиглалтын хэлтсийн мэргэжилтэн
	Ч.Мөнхбаяр	Өмчийн бүртгэл, хувьчлалын хэлтсийн ахлах мэргэжилтэн
<b>Баянгол, Сонгинохайрхан дүүрэгт :</b>		
	Х.Баттуяа	Өмчийн төлөөлөл, менежментийн хэлтсийн мэргэжилтэн
	А.Эрдэнэмөнх	Өмчийн төлөөлөл, менежментийн хэлтсийн мэргэжилтэн
	Б.Эрдэнэмөнх	Өмчийн мэдээлэл хяналт, ашиглалтын хэлтсийн мэргэжилтэн
	М.Энхбаяр	Өмчийн бүртгэл, хувьчлалын хэлтсийн мэргэжилтэн
<b>Чингэлтэй, Хан-Уул дүүрэгт:</b>		
	Ч.Чулуунтөгс	Өмчийн төлөөлөл, менежментийн хэлтсийн мэргэжилтэн
	Ч.Хоролгарав	Өмчийн төлөөлөл, менежментийн хэлтсийн мэргэжилтэн
	Ц.Цолмон	Өмчийн мэдээлэл хяналт, ашиглалтын хэлтсийн мэргэжилтэн
	Ч.Мөнхбаяр	Өмчийн бүртгэл, хувьчлалын хэлтсийн ахлах мэргэжилтэн
<b>Багануур дүүрэгт:</b>		
	С.Сэржжаргал	Өмчийн төлөөлөл, менежментийн хэлтсийн дарга
	М.Энхболд	Өмчийн төлөөлөл, менежментийн хэлтсийн ахлах мэргэжилтэн
	Х.Баттуяа	Өмчийн төлөөлөл, менежментийн хэлтсийн мэргэжилтэн
	Б.Адъяа	Өмчийн төлөөлөл, менежментийн хэлтсийн мэргэжилтэн
	Ж.Сувданзаяа	Өмчийн мэдээлэл хяналт, ашиглалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн

	О.Уранчимэг	Өмчийн мэдээлэл хяналт, ашиглалтын хэлтсийн мэргэжилтэн
<b>Багахангай дүүрэгт:</b>	Н.Болормаа	Өмчийн төлөөлөл, менежментийн хэлтсийн мэргэжилтэн
	А.Эрдэнэмөнх	Өмчийн төлөөлөл, менежментийн хэлтсийн мэргэжилтэн
<b>Налайх дүүрэгт :</b>	С.Сэржжаргал	Өмчийн төлөөлөл, менежментийн хэлтсийн дарга
	Ч.Чулуунтөгс	Өмчийн төлөөлөл, менежментийн хэлтсийн мэргэжилтэн
	М.Энхбаяр	Өмчийн бүртгэл, хувьчлалын хэлтсийн мэргэжилтэн
<b>Нийслэлийн Амгалан, Өргөө, Хүрээ амаржих газаруудад</b>	С.Ариунжаргал	Өмчийн төлөөлөл, менежментийн хэлтсийн мэргэжилтэн
	Б.Эрдэнэмөнх	Өмчийн мэдээлэл хяналт, ашиглалтын хэлтсийн мэргэжилтэн
	Б.Адъяа	Өмчийн төлөөлөл, менежментийн хэлтсийн мэргэжилтэн
	Ц.Цолмон	Өмчийн мэдээлэл хяналт, ашиглалтын хэлтсийн мэргэжилтэн
	Ж.Сувданзаяа	Өмчийн мэдээлэл хяналт, ашиглалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн
Ажлын хэсгийн нарийн бичиг	Ч.Хоролгарав	Өмчийн төлөөлөл, менежментийн хэлтсийн мэргэжилтэн

Нийслэлийн Өмчийн, ашиглалт удирдлагын  
газрын даргын 2020 оны 11... -р сарын 05 өдрийн  
1124-р тушаалын хоёрдугаар хавсралт



**НИЙСЛЭЛИЙН 9 ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ЭД ХӨРӨНГИЙН АШИГЛАЛТ, ХАДГАЛАЛТ, ХАМГААЛАЛТАД ХЯНАЛТ,  
ШАЛГАЛТ ХИЙХ, ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТ ДҮГНЭХ АЖЛЫН УДИРДАМЖ**

Нэг. Зорилго

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 55 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Нийслэлийн өмчийг эзэмшүүлэх гэрээ"-ний 2.5-ийн дагуу нийслэлийн 9 дүүргийн Засаг даргын Тамгын газрын эд хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, хөрөнгийн зарцуулалт, бүртгэлд хяналт, шалгалт хийж, зөрчил дутагдлыг арилгах, учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авахад шалгалтын зорилго оршино.

Хоёр. Эрх зүйн үндэс

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нийслэлийн өмчийн ашиглалт, удирдлагын газрын дүрмийн 3.4 дэх хэсгийг тус тус эрх зүйн үндэс болгоно.

Гурав. Хамрах хүрээ

Нийслэлийн 9 дүүргийн Засаг даргын Тамгын газрын эд хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, захиран зарцуулалт, хууль тогтоомж, өмчийн талаар гарсан шийдвэрийн хэрэгжилтийг шалгана. Үүнд:

1. Хөрөнгийн бүртгэл, эзэмшил, ашиглалт, хамгаалалтын байдалд үзлэг хийж, шаардлагатай тохиолдолд түүвэрчилсэн тооллого хийх
2. Үл хөдлөх хөрөнгийг нэг бүрчлэн бүртгэлтэй тулган үзэж, ашиглалтын байдалтай танилцаж, ашиглалтыг сайжруулах талаар санал боловсруулах
3. Өмч хамгаалах байнгын зөвлөлийн ажлын байдал, төлөвлөлт, үр дүн,
4. Тогтоол, захирамж, албан бичгийн дагуу эд хөрөнгийг бүртгэлд тусгаж, заасан хугацаанд биелэлтээ эргэж тайлагнасан байдал,
5. Улс, нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгөөр бэлтгэгдсэн хөрөнгийг журмын дагуу бүртгэсэн эсэх
6. Хөрөнгийг хууль, журмын дагуу данснаас хассан эсэх,
7. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу 2020 оны хагас жилийн тооллогыг хийсэн байдал,

8. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу худалдан авалт хийсэн эсэх, санхүүжилтийн зарцуулалт,
9. Тухайн байгууллагын удирдлага өөрчлөгдөн, шинээр томилогдсон үед хууль журмын дагуу ажил хүлээлцсэн эсэх.
10. Нийслэлийн Өмчийг эзэмшүүлэх гэрээний байгуулсан эсэх / НӨАУГ-ын тушаал шийдвэрийн биелэлт

Дөрөв. Гэрээ дүгнэх хугацаа, хуваарь

Шалгалтын ажлыг 2020 оны 11 дүгээр сарын 09-ний өдрөөс 2020 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн хооронд явуулж, тайланг 2020 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн дотор гаргана.

Тав. Гэрээ дүгнэх шалгалт хийх арга, хийгдэх ажил

1. Шалгалтыг баримт бичиг хянан үзэх, хөрөнгийн чанар байдалтай биелэн танилцах, гэрэл зураг авах, шаардлагатай тохиолдолд дүрс бичлэг хийх зэрэг аргуудаар хийж гүйцэтгэнэ.

2. Гэрээний биелэлтийг батлагдсан үзүүлэлт тус бүрээр дүгнэж, нийлбэр оноогоор нэгдсэн дүнг гаргана. Үүнд:

90-100	Бүрэн хангалттай
80-89.9	Хангалттай
70-79.9	Ажил сайжруулах
69.9-с доош	Хангалтгүй

1. Гэрээний биелэлтийн дүнг тухайн байгууллагын удирдлагад танилцуулан, гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажуулна.


2. Гэрээний үүргээ биелүүлээгүй байгууллагын удирдлагад, шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдалд заавар, зөвлөмж өгөх, зөрчлийг арилгах арга хэмжээ авна.

Зургаа. Гэрээ дүгнэсэн дүнг гаргах

1. Хуваарилагдсан ажлын хэсэг шалгалтын дүнгийн талаар нэг бүрчлэн илтгэх хуудас бичиж, ажлын хэсгийн нарийн бичгийн дарга нэгтгэнэ.

2. Нийслэлийн өмчийн ашиглалт, удирдлагын газрын Удирдлагын зөвлөлд нэгдсэн тайланг 2020 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор танилцуулна.

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын даргын 2020 оны ...11.....-р сарын .05.....-ны өдрийн ...1/24.....-р тушаалын гуравдугаар хавсралт



Нийслэлийн өмчийг эзэмшүүлэх гэрээний биелэлтийг дүгнэх хүснэгт


Байгууллагын нэр:..... дүүрэг

№	Үзүүлэлт	Гэрээ дүгнэх үзүүлэлт	Авбал зохих оноо	Авсан оноо
1.	Нийслэлийн өмчийн ашиглалт, удирдлагын газрын тушаал, шийдвэрийн биелэлт	Нийслэлийн Өмчийг эзэмшүүлэх гэрээ байгуулсан эсэх	5	
		Барилгын хувийн хэргийн хөтлөлт, баяжуулалт	5	
		Газрын гэрчилгээ, гэрээ, кадастрын зураг, газрыг дахин үнэлж данс бүртгэлд тусгасан байдал	5	
		Барилга ашиглалтын төлөв байдал	15	
		Өмч хамгаалах байнгын зөвлөлийн ажлын байдал	5	
		Өмч хөрөнгийн эзэмшил, ашиглалт, хадгалалт, хамгаалалтын байдал, ашиглалтыг сайжруулах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ	10	
<b>Дүн</b>			<b>45</b>	
2.	Хөрөнгийн хөдөлгөөний талаар	Үндсэн хөрөнгийг хууль журмын дагуу бэлтгэсэн эсэх /худалдан авах/	10	
		Улс, нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгө оруулалт, хандив тусламжаар бий болсон хөрөнгийг цаг хугацаанд нь бүртгэлжүүлэх арга хэмжээ авсан эсэх	10	
		Үндсэн хөрөнгийг хууль журмын дагуу данснаас хассан эсэх /акталсан хөрөнгө, устгалын акт/	5	
<b>Дүн</b>			<b>25</b>	
3.	Санхүүгийн тайлан, хөрөнгийн бүртгэл, хөтлөлт тайлагналт	Жилийн эцсийн тайланг НӨАУГ-ын цахим системд хугацаанд нь нэгтгүүлсэн эсэх,	5	
		Тооллогыг хуулийн дагуу хийсэн эсэх тооллогын бүртгэл тайлагналт,	5	
		Хөрөнгийг НББ-ийн хуулийн дагуу зөв ангилж бүртгэсэн эсэх	5	
<b>Дүн</b>			<b>20</b>	
4.	Түрээсийн төлбөр тооцоо	Хөрөнгө түрээслэх, цуцлахдаа зөвшөөрөл авч, гэрээ байгуулж батлуулсан байдал	10	
<b>Дүн</b>			<b>10</b>	
<b>Нийт дүн</b>			<b>100</b>	

ГЭРЭЭ ДҮГНЭСЭН:

ТАНИЛЦСАН:

Нийслэлийн өмчийн Ашиглалт, удирдлагын газр  
даргын 2020 оны ...11... сарын ...08...-ны өдр  
...1524... дугаар тушаалын дөрөвдүгээр хавср



НИЙСЛЭЛИЙН 9 ДҮҮРГИЙН УДИРДЛАГАТАЙ  
БАЙГУУЛСАН “НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙГ ЭЗЭМШҮҮЛЭХ ГЭРЭЭ”-НИЙ  
БИЕЛЭЛТИЙГ ДҮГНЭХ ЗАРДЛЫН ТӨСӨВ

№	Зардлын нэр	Байгууллагын тоо	Нэгж үнэ	Тоо хэмжээ /литрээр/	Бүгд үнэ /төгрөгөөр/	Хянасан нь
1.	Шатахууны тооцоо /Нийт - 410 литр/	9 дүүргийн Засаг даргын Тамгын газар	1600	640	1,072,000	
2.	Бичгийн цаас - 9 Хавтас - 9		Шаардах хуудсаар			
3.	Багануур, Багахангай дүүрэгт ажиллах томилолтын зардал	6 хүн	36,000	2 өдөр	432,000	
	Дүн				1,504,000	

Хянасан:

Ерөнхий ня-бо

Н.Уранчимэг

Боловсруулсан:

Өмчийн төлөөлөл менежментийн хэлтсийн  
мэргэжилтэн

Ч.Хоролгарав - и